



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/209

Номгон

Бүртгэл хөтлөлтийн аймгийн үзлэг  
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3,4,1 Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний төрийн бүтээмжийг сайжруулах, албан хаагчдыг тогтвортой ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний 6.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн үзлэгийг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон төсвийн байгууллагуудад 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд явуулахаар тогтоосугай.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн аймгийн үзлэг явуулах ажлыг удирдан зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлтийн үзлэг зохион байгуулах төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн аймгийн үзлэг явуулах зардал 12,000,000 (Арван хоёр сая) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Үзлэгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэст даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310527

137  
Аймгийн Засаг даргын Тамгын Газрын 1-дүгээр  
сарын 20-ны өдрийн 1/20-дүгээр захирамжийн



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТЛӨЛТИЙН АЙМГИЙН  
ҮЗЛЭГ ЯВУУЛАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

С.Байгалмаа - Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд :

Б.Мөнхбат - Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

Л.Жаргалцэцэг - Санхүүгийн хяналт аудитын албаны дарга,  
Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч

Ц.Самбууням - Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч, улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

Ш.Гэрэлсүх - Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн, улсын байцаагч

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_



Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дүгээр сарын 20-ны  
өдрийн 1009 дүгээр захирамжид хоёрдугаар хавсралт

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТЛӨЛТИЙН АЙМГИЙН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа /он, сар/	Шаардагдах хөрөнгийн хэмжээ /мян.төг/	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6
<b>1. Нягтлан бодох бүртгэлийг сайжруулах, Санхүү, бүртгэлийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, удирдах ажилтан, албан хаагчдад санхүүгийн мэдлэг олгох</b>					
1.1	НББ хөтлөлтийн үзлэг явуулахад хэрэглэгдэх баримт бичгийг боловсруулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.04	0	Бүртгэлээр тавих хяналт сайжрах
1.2	НББ хөтлөлтийн үзлэгийг 19 сумд зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сумдын санхүүгийн алба	2023.05	2100,0	Бүртгэлээр тавих хяналт сайжрах
1.3	НББ хөтлөлтийн үзлэгийг аж ахуйн нэгж байгууллага, төсвийн байгууллагад зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, ММНБИ-ийн Баянхонгор аймаг дахь салбар	2023.05	0	Бүртгэлээр тавих хяналт сайжрах
1.4	Сумдын төсвийн байгууллагуудад Аймгийн З/Д-ын А/683 дугаар захирамж, Засгийн газрын 2022 оны	Санхүү, төрийн сангийн хэлтэс,	2023.05	0	Хуулийн хэрэгжилтийг хангана

1	2	3	4	5	6
	491 дүгээр тогтоолын хэрэгжилтийг шалгах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	Сумдын санхүүгийн алба			
1.5	Төсөвт байгууллагуудын эд хариуцагчдыг сургалтад хамруулж, эд хариуцагчийн үнэмлэхтэй болгох	Санхүү, төрийн сангийн хэлтэс, ММНБИ-ийн Баянхонгор аймаг дахь салбар	2023.04,09 сар	100,0	Эд хариуцагчдын мэргэжил, мэдлэгийн түвшин, ур чадвар сайжирсан байна
1.6	Цалин, тэтгэмж, эд хөрөнгийн тооллого, албан хаагч ажилд авах, чөлөөлөхтэй холбоотой тушаал шийдвэрийн загвар бэлтгэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс	2023.05	1000,0	Бүх төсөвт байгууллагууд загвар эмхтгэлтэй болсон байна
1.7	Богд, Эрдэнэцогт сумын санхүүгийн албыг бэхжүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагаа	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сумын санхүүгийн алба	2023.06	200,0	Санхүүгийн зөрчил дутагдалгүй ажиллах
1.8	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дүгнэлт, Санхүүгийн хяналт, аудитын албаны эрэмбээр эрсдлийн үнэлгээ өндөр байгууллагын ажил сайжруулах, зөвлөн туслах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, ММНБИ-ийн Баянхонгор аймаг дахь салбар	2023.05-09 сар	200,0	Санхүүгийн зөрчил дутагдалгүй ажиллах
1.9	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудын дунд "Шилдэг нярав шалгаруулах" болзолт уралдаан зарлах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.05	1500,0	Анхан шатны бүртгэл, агуулахын эмх цэгц, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна
1.10	Төрийн сангийн цахим шилжилттэй холбоотой "АСТ" тэмцээн зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.05	0	Төрийн сангийн цахим шилжилттэй холбоотой хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ

1	2	3	4	5	6
1.11	Нягтлан бодогчдын дунд холбогдох хууль тогтоомж, IQ, танин мэдэхүй сэдэвт "АХА" тэмцээн зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.09	1000,0	Хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна
1.12	Нягтлан бодогчдын судалгааг шинэчлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.04	0	Мэдээллийг шинэчлэх
1.13	Сумдад ажиллах хүсэл сонирхолтой санхүүгийн сургууль төгссөн төгсөгчдийн судалгаа авах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.04	0	Хүний нөөц бүрдүүлэх
1.14	Сумдын санхүүгийн албадын дунд "Цахим санхүүгийн алба" уралдаан зарлах, санхүүгийн нэгдсэн тайланд илэрсэн алдаа зөрчил, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхаарх зүйлсийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогчид	2023.05	200,0	Тулгамдаж буй асуудлуудыг нэгтгэж, цаашид анхаарх арга замыг тодорхойлох
1.15	Боловсрол, Эрүүл мэнд, Соёл, Орон нутгийн төсвийн удирдлагуудад төсвийн шинэчлэл, цахим шилжилт, төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжуудаар сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.06	0	Салбар бүрийн мэдээллээр хангагдана
1.16	Сангийн яам болон салбарын яамдуудтай хамтран санхүүчдын дунд бүртгэлийн чиглэлээр сургалт явуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.06	2000,0	Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр гарч байгаа алдаа зөрчил буурах
1.17	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тооцох журамын 3.4 дэхь заалтын дагуу Том аж ахуйн нэгж байгууллагын	Санхүү, төрийн сангийн хэлтэс, ММНБИ-ийн Баянхонгор аймаг дахь салбар	2023.06	0	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах

1	2	3	4	5	6
	санхүүгийн програмын судалгаа, бүртгэл хөтлөлтийн үзлэг				
1.18	Жижиг дунд аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт санхүүгийн тайлан гаргалтаар сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс ММНБИ-ийн Баянхонгор аймаг дахь салбар Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс	2023.09	500,0	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах
1.19	Шинээр томилогдсон нягтлан бодогч нарт чадвахжуулах сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.06	200,0	Санхүүгийн сахилга бат сайжирна
1.20	Нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг таниулж, сурталчлах ажлыг зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.09	1000,0	Мэргэжлийн ёс зүй, харилцааны соёл дээшилнэ
1.21	Санхүү бүртгэлийн ажилтнуудад харилцаа хандлагын сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.10	1000,0	Санхүүгийн алба, бүртгэлийн ажилтнуудын идэвхи санаачлага сайжирна
1.22	Байгууллагын албан хаагчдад санхүүгийн мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2023.05-10 сар	0	Удирдах ажилтан, албан хаагчдын санхүү, хуулийн мэдлэг сайжирсан байна.
1.23	Спортын арга хэмжээ	Санхүү төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Статистикийн хэлтэс,	2023.10	1000,0	Санхүүгийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирах

1	2	3	4	5	6
		Нийгмийн даатгалын хэлтэс, Төрийн аудитын Баянхонгор дахь салбар, Монгол банк			

\_\_\_\_\_ ооо \_\_\_\_\_